



2025 он 07 сар 04 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Үнэт цаас худалдан авахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК нь дахин санхүүжилт хийх зорилгоор “Бета Лизинг” ХХК-аас 32,000,000,000 /гучин хоёр тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас /өрийн хэрэгсэл/-ыг дараах хөтөлбөр, нөхцөлийн дагуу худалдан авахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй. Үүнд:

Үнэт цаас гаргагч	“Бета Лизинг” ХХК
Үнэт цаасны нэр, код	Бета бонд 1
Үнэт цаасны төрөл	Өрийн хэрэгсэл (бонд)
Гаргаж буй зах зээл	Биржийн бус зах зээл (Over-the-Counter Market)
Нийт худалдан авах дүн	32,000,000,000 төгрөг
Худалдан авах тоо ширхэг	32,000 ширхэг
Бондын нэрлэсэн үнэ	1,000,000 төгрөг
Бондын хугацаа	12 сар
Бондын нөхцөл	Хаалттай бонд
Жилийн хүү	19.0%
Хүүгийн төрөл	Тогтмол хүүтэй хөтөлбөртэй бонд
Хүү төлөх давтамж	Улирал бүр
Үндсэн төлбөр төлөлт	Хугацааны эцэст
Үүргийн гүйцэтгэл хангуулах арга	Байхгүй
Бондын зарцуулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт

2. Үнэт цаас худалдан авахтай холбоотой гэрээ, хэлцэл болон бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д олгосугай.
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР